


Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ,

Бид Баянхөндий алтны ордын олборлолтыг эхлүүлэх түүхэн мөчийн ирмэг дээр ирээд байна. Энэхүү амжилт нь Эрдэнэ Ресурсийн хувьд хайгуулын шатнаас олборлолтын шат руу руу шилжиж, хөгжлийн шинэ түвшинд гарч буйг илтгэж байна. Манай геологи хайгуулын баг газрын дөт гүнд өндөр агуулга бүхий алтны төслийг нээн илрүүлснээс хойш 10 жил, ТЭЗҮ боловсруулснаас хойш 5 жилийн хугацаа өнгөрчээ. Хайгуулаас олборлолтын шат руу хөгжүүлж буй төслүүдтэй харьцуулахад энэ нь маш богино хугацааны шилжилт юм. Баянхөндий төсөл нь дэлхийн хэмжээнд хамгийн өндөр агуулгатай, илээр олборлох боломжтой ордуудын нэг болж, харьцангуй бага нэгж зардалтайгаар (AISC) үйлдвэрлэл явуулах нөхцөлийг бүрдүүлсэн онцлогтой. Түүнчлэн, алтны үнэ түүхэн дээд түвшинд хүрч буй энэ цаг үед Баянхөндий төслийн олборлолт эхлэх гэж байгаа нь үнэ цэнээ улам бүр нэмэгдүүлэх боломжтой болсон.

Бид Баянхөндий төслийн алтны олборлолтыг эхлүүлэхээс гадна Хөндий Эрдсийн Дүүрэг дэх бусад нөөц бүхий төслүүд болон хэтийн төлөвтэй талбайг үргэлжлүүлэн хөгжүүлсээр байна. Хөндий Эрдсийн Дүүрэг нь Ази тивийн хамгийн ирээдүйтэй, ашигт малтмалын шинэ бүс нутгуудын нэг бөгөөд бид энэ бүс нутагт дөрвөн орд, алт болон суурь металлын олон тооны өндөр агуулгатай хэтийн төлөв бүхий илрэлүүдийг тогтоогоод байна. Цаашлаад бид өнгөрсөн 10 жилийн амжилтыг үргэлжлүүлж, ирэх 10 жилд ч энэ бүс нутагт хайгуул, нээлтийн амжилтыг дахин давтах бүрэн боломжтой гэж итгэж байна.

Баянхөндий: Арван жилийн хөдөлмөрийн үр дүн – Олборлолт руу ойртож буй өндөр агуулга бүхий алтны төсөл

2015 оны дунд үед манай геологи хайгуулын баг Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн өмнө нь судлагдаагүй хэсгээс алт агуулсан хэд хэдэн чулуулгийн дээж авч, хамгийн өндөр нь 4,380 г/т алт агуулж байв. 2015 оны сүүлээр суваг малталт, геофизикийн судалгаануудыг гүйцэтгэсэн ба хамгийн анхны өрөмдлөгийн цооногоор газрын дөт гүнд маш өндөр агуулга бүхий аномаль алт огтолсон нь 27.5 г/т алтны агуулга бүхий 7 метрийн интервал байв. Өрөмдлөг гүйцэтгэсэн эхний 96 цооногийн 95 цооногт нь алтны аномаль илрэл таарснаар бид томоохон алтны ордыг нээсэн гэдэгтээ итгэлтэй болж, нөөц тогтоох, эдийн засгийн үр ашигтай байдалд үнэлгээ хийх техникийн судалгааг эхлүүлсэн.



Зураг: ВКД-231 цооногийн дээж – 2,200 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал

2016-2018 оны хооронд Эрдэнэ Ресурс нь нийт 42,410 тууш метрийн өрөмдлөг хийж, 2018 оны 3-р улиралд Баянхөндий төслийн анхан шатны нөөцийн тооцооллыг танилцуулсан. 2019 болон 2020 онд Баянхөндий төслийн техникийн судалгаа, 2020 оны 8-р сард төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан. Энэхүү судалгаануудын үр дүнд Баянхөндий төслийг дэлхийн хэмжээний хамгийн өндөр агуулгатай ил уурхайнуудын нэг гэдгийг баталгаажуулсан.

Covid-19 цар тахлын улмаас бүтээн байгуулалтын ажлууд хойшлогдсон хэдий ч 2020-2021 онуудад манай хамт олон Баянхөндий төслийн зураг төсөл, инженерчлэл болон тусгай зөвшөөрлийн ажлуудыг эрчимжүүлж ажилласан. 2023 оны 1-р сард Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)-тэй төслийн санхүүжилт, хөгжүүлэлттэй холбоотойгоор Стратегийн Түншлэлийг байгуулсан ба түүнтэй зэрэгцэн төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн. Мөн 2021 онд нээн илрүүлсэн Хар Морин Дэл ордын нөөц болон зардлуудыг шинээр тооцоолж, шинэчилсэн ТЭЗҮ-д тусгасан.

2024 оны 1-р сард стратегийн түнш ММС-тэй хамтран, төсөл хэрэгжүүлэгч Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)-ийн Баянхөндий төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх албан ёсны шийдвэрийг гаргасан. 18 сарын бүтээн байгуулалтын хугацаанд нийт 4 сая хүнцагийн хөдөлмөр, оргил үедээ 769 ажилтан ажилласны, үр дүнд 2025 оны 6-р сарын 12-нд барилга байгууламжуудыг улсын комисст хүлээлгэн өглөө.



Зураг: Баянхөндий төслийн барилга, бүтээн байгуулалтын хамт олон ажлаа танилцуулж байна – 2025 оны 6-р сар

Баянхөндий төслийн бүтээн байгуулалт, барилгын ажлууд үндсэндээ дуусах шатандаа орсон тул уулын бэлтгэл ажил болон хүдэр хадгалах талбай (ROM)-н ажлуудыг эхлүүлсэн. Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд болох хацарт бутлуур, бөмбөлөгт болон хагас өөрөө нунтаглах тээрэм, уусгалт болон элюцийн хэлхээ, алтны өрөөний туршилт, тохируулгыг хуваарийн дагуу ахиулж байна. Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран химийн бодисын зөвшөөрлийг авах ажлыг эхлүүлсэн ба 2025 оны 3-р улирлын сүүлээр хүдэр боловсруулж эхлэх боломжтой гэж үзэж байна. Баянхөндийн боловсруулах үйлдвэр нь өдөрт 2,000 тонн өндөр агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 85,000 унц алт олборлох хүчин чадалтай.



Зураг: Баянхөндий төслийн боловсруулах үйлдвэр – 2025 оны 6-р сар

Хүний нөөц, дэд бүтэц ба материал хангамж

Энэ оны 6-р сарын эхэнд манай хамт олон захиргааны оффис болон 370 хүний багтаамжтай “Мазаалай” кэмпдээ нүүж орсон. Монголын говийн баавгайг бэлгэдэн нэрлэсэн уг кэмпэд хоолны заал, угаалгын газар, дэлгүүр, биеийн тамирын заал зэрэг бүх шаардлагатай байгууламжууд бүрэн шийдэгдсэн. Мөн Мазаалай кэмпиин дэргэд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгуулсан ногоон байгууламжид нутгийн уугуул ургамлуудын үрсэлгээг хийж, тарьсаар байна. Ойролцоо орших нисэх зурвас нь аймгийн төв болон Улаанбаатар хотоос нислэг үйлдэх боломжийг бий болгох ба кэмпээс уурхайн бүс хүртэл 8 км авто замыг шинээр барьж, ажилтнуудыг аюулгүй, үр ашигтай шилжилт хөдөлгөөн хийх нөхцөлийг хангалаа. Түүнээс гадна, аймгийн төв болон Шинэжинст сумаас уурхайн бүс рүү ажилтнуудыг тээвэрлэх зорилгоор нийтийн авто замуудыг шинэчилж, сайжруулсан болно.у,



Зураг: Баянхөндий төслийн Мазаалай кэмп – 2025 оны 6-р сар

Байгаль орчны шинэлэг шийдэл ба усны хэмнэлт

Баянхөндий төсөл нь Монгол Улсад анх удаа хуурай хаягдал болон уурхайн хаягдал чулуулгийг хамтад нь байршуулах хаягдлын нэгдсэн байгууламж (“IWF”)-ийг байгууллаа. Бүх хаягдлыг Монгол Улс болон олон улсын стандартын дагуу боловсруулахаас гадна усыг шүүн цэвэршүүлж 84%-ийг дахин ашиглана. Энэхүү дэвшилтэт шийдэл нь говийн бүс нутагт уурхайн үйл ажиллагааны усны хэрэглээг огцом бууруулахын зэрэгцээ нойтон хаягдлаас үүсэх байгаль орчны эрсдэлийг багасгах чухал ач холбогдолтой.



Зураг: Хаягдлын нэгдсэн байгууламж ("IWF") – 2025 оны 6-р сар

Баянхөндий ордыг тусгай зөвшөөрлийн хайгуул хийгдээгүй хэсэгт нээн илрүүлснээс хойш 10 жилийн хугацаа өнгөрчээ. Салбарын дунджаас хурдан хугацаанд хайгуулаас олборлолт руу шилжсэн Баянхөндий төслийн бас нэг онцлог нь нэг унц алт олборлох нийт зардлын хэмжээ багад оршино. Эдгээр нь манай хамт олны хүч хөдөлмөр, стратегийн түнш MMC болон туслан гүйцэтгэгчид, зөвлөхүүдийн хамтын ажиллагааны бодит илэрхийлэл бөгөөд цаашид ч ижил амжилтыг давтах боломжтойг харуулж байна.

Average lead times of mines from discovery to production, 2002-2023



2023.04.04


*Алт, зэс, никель, мөнгө болон цайрын 127 уурхай хамрагдсан судалгаа

Эх сурвалж: S&P Global Market Intelligence.

© 2023 S&P Global

Баянхөндий төслийн урт хугацааны үнэ цэн – Ирээдүйн 10 жилийн төлөв

Баянхөндий орд нь 10 гаруй км үргэлжлэх структураар хянагдсан хүдэржсэн алтны системийн төвд оршдог. Иймээс манай ирээдүйн зорилт бол Баянхөндийн уурхайгаас бий болох мөнгөн урсгалыг ашиглан уурхайн үйл ажиллагааг өргөтгөх, одоогийн уурхайн төлөвлөлтийн суурь болох 500 мянган унц алтны нөөцийг нэмэгдүүлэх юм.



Зураг: Баянхөндий эпитеpmаль систем – 150 метрээс гүнд хязгаарлагдмал хайгуул хийгдсэн 10 км бүхий хүдэржсэн структур


Ирээдүйд тэлэх боломжтой талбай нь Баянхөндий ордтой залгаа орших өндөр агуулга бүхий бүсүүд юм. Энэхүү талбайд 2024 оны эцэст гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр өнөөгийн ил уурхайн хязгаарын гадна өндөр агуулга бүхий интервалуудыг огтолсон. Тухайлбал, BKD-377 цооногт 7.3 г/т алтны агуулга бүхий 42 метрийн интервал огтолж, нөөцийн хилийг баруун зүгт тэлсэн. Уурхайн төлөвлөлтийн болон геологийн баг нь алтны үнийн нөлөөллийн хүрээнд дээрх үр дүнг уурхайн шинэчилсэн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.



Зураг: Баянхөндийн тэлэлтийн өрөмдлөгийн үр дүнгүүд –2024 оны 3-р улирал

Баянхөндий ордоос хойд зүгт газрын дөт гүнд маш өндөр агуулга бүхий Өмнөд Хар Морин Дэл орд байрладаг. Одоогийн уурхайн төлөвлөлтөд багтсан Өмнөд Хар Морин Дэл ордын 50,000 унц алтны нөөцөөс гадна Хойд Хар Морин Дэл, Зүүн Дэл, Алтан Сум зэрэг илрэлүүдийг агуулсан 20 гаруй км² бүхий Хар Морь бүс нутаг нь цаашдын хайгуул, судалгааны ажилд нээлттэй хэвээр байна. Энэхүү бүсэд хийсэн өрөмдлөгийн 70%-д алтны аномаль хүдэржилтийг огтолсон ба нэмэлт хайгуул хийснээр алтны нөөцийг нэмэгдүүлэх боломжтой.

Баянхөндийгөөс баруун зүгт гадаргын эрдэсжилтгүй талбайд Улаан ордыг нээн илрүүлсэн. Алтны хүдэржилт нь газрын гадаргын 80 метрээс эхэлдэг энэхүү систем нь гүндээ нээлттэй байгаа нь гүний хайгуулын боломжийг баталгаажуулсан нээлт болсон. Тухайлбал, UDH-121 цооног нь 450.3 метрт алтны хүдэржилтээр төгссөн ба 8.7 г/т алтны агуулга бүхий 27 метр багтаасан 1.1 г/т алтны агуулга бүхий 335.3 метрийн интервал огтолсон. Энэхүү нээлт нь зөвхөн Улаан талбайн гүний хайгуулын боломжуудыг харуулахаас гадна Баянхөндий эпитермаль системийн хэтийн төлөвийг харуулж байна.




Зураг: Зүүн өмнөд Улаан талбайд Хөндий дүүргийн хамгийн өргөн хүдэржилтийг огтолсон

Баянхөндий ордын ТЭЗҮ-д тусгагдсан уурхай ашиглах зургаан жилээс илүү урт хугацаанд, тогтвортой, өртөг багатайгаар олборлох алсын харааг биелүүлэхийн тулд Баянхөндий, Хар Морь болон Улаан төслүүдийг цогцоор нь авч үзэх шаардлагатай. Нөөцийг ихээхэн хэмжээгээр нэмэх боломжуудад уурхайн хязгаарыг тэлэх, Хар Морь трендийн хэтийн төлөв болон гүндээ хайгуул хийн нөөцийг нэмэгдүүлэх боломжууд багтаж байна. Мөн боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг харьцангуй бага хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлэх инженерийн нарийвчилсан судалгааг хийж байна.

Хязгаарлагдмал хайгуул хийгдсэн Хөндий Эрдсийн Дүүрэг– Олон арван жилийн боломжтой бүс нутаг

Эрдэнэ Ресурс нь Хөндий Эрдсийн Дүүрэгт Хөндий, Улаан тусгай зөвшөөрлөөс гадна хоёр тусгай зөвшөөрлийн хувийг эзэмшдэг – Алтан Нар алт, полиметаллын орд (ММС-тэй хамтран 50% эзэмшдэг) ба Зуун Мод молибден-зэсийн порфирийн орд (100% эзэмшдэг) багтана. Баянхөндий алтны олборлолтыг эхлүүлснээр дээрх төслүүдэд төвлөрөн, хөгжүүлэлт хийхээр төлөвлөж байна.




Зураг: Хөндий Эрдсийн Дүүрэг, ~4000км² хэтийн төлөв бүхий талбай

Алтан Нар: Хөндий Эрдсийн Дүүрэг дэх хоёр дахь алтан боломж

Баянхөндий ордоос хойд зүгт 16 км-т өндөр агуулга бүхий эпитеpmаль алтны Алтан Нар орд оршдог. Энэхүү орд нь 5.6 км хүдэржсэн трендийн дагуу оршдог ба гүндээ болон судлын дагуу нээлттэй. Алтан Нар нь дундаж сульфиджилт төрлийн ордод хамаардаг ба Баррик Гоулдын Поргера уурхай (Папуа Шинэ Гвиней), Рио Тинтогийн олборлож байсан Келиан уурхай (Индонез), Лундинын Фрута Дел Норте (Эквадор), Зижиний Буритика (Колумб) зэрэг ордуудтай ижил төстэй геологийн онцлогтой. Энэ төрлийн ордууд нь ерөнхийдөө нуман тогтоц (арлан нум г.м.) дахь порфирийн интрузивын дээд хэсэгт тохиолдох ба хүдэржилт нь босоо гүн чиглэлд 500 гаруй метр үргэлжлэх боломжтой байдаг.

Алтан Нар ордыг 2011 онд нээсэн ба 2015 онд Баянхөндий ордыг нээх хүртэл компанийн гол төсөл байсан. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд компани нь Баянхөндий төсөлд төвлөрөн ажилласан тул Алтан Нар төслийн талбайд хязгаарлагдмал хайгуул хийгдсэн. 2018¹ онд RPMGlobal нь Алтан Нар ордын нөөцийн тооцооллыг боловсруулсан ба 2.8 г/т алтны дундаж агуулга бүхий 453,000 унц алттай дүйцэх нэгж ("AuEq") бүхий 5 сая тонн бодитой нөөц, 2.5 г/т алтны агуулга бүхий 277,000 унц алттай дүйцэх нэгж ("AuEq") бүхий 3.4 сая тонн боломжтой нөөц тодорхойлогдсон. Энэхүү нөөцийн 90% нь газрын дөт гүнд буюу гадаргаас 150 метр хүртэл гүнд агуулагдаж байгаа ба нийт нөөцийн ихэнх нь зөвхөн хэтийн төлөв бүхий 18 илрэлийн хоёр хэсэгт л төвлөрсөн байгаа нь гүн болон дагуу тэлэх асар их боломж байгааг илтгэнэ. Нэмж дурдахад, Алтан Нар тусгай зөвшөөрлийн талбайд Оюут Хөндий зэсийн хэтийн төлөв бүхий талбай, Номин Тал зэс-алтны хэтийн төлөв бүхий талбай багтдаг.



Зураг: Алтан Нар хүдэржсэн тренд болон хайгуулын хэтийн төлөв бүхий талбай

Алтан Нарын хүдрийг Баянхөндийн дэд бүтцийг ашиглан боловсруулах боломжуудыг судлан, эерэг үр дүн бүхий техникийн тайланг танилцуулсан. Гэвч Алтан Нар ордын хүдрийн онцлог болон тусгай зөвшөөрлийн талбайн хэтийн төлөвийг харгалзан үзвэл жилд 75,000 - 100,000 унц алтны баяжмал, дагалдах

¹ "Altan Nar Gold-Polymetallic Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia, National Instrument 43-101 Technical Report" нэртэй 2021 оны 3 сарын 29-нд боловсруулсан техникийн тайлантай SEDAR+ дэх хуудсаас танилцана уу.

бүтээгдэхүүн гаргах хүчин чадал бүхий тусдаа боловсруулах үйлдвэр барих нь эдийн засгийн хувьд оновчтой хувилбар байж болзошгүй байна. Ирээдүйн хайгуулын судалгаагаар нөөцийг нэмэгдүүлэх, өндөр агуулга бүхий бүсүүдийг тодорхойлох болон трендийн дагуу хайгуул хийгдээгүй 16 хэтийн төлөв бүхий бүсүүдийг судлах ажлуудыг гүйцэтгэх ба үр дүнгүүд нь ирээдүйн техникийн судалгаа болон эдийн засгийн тооцооллын суурь болно.

Зуун Мод: Ази тивийн хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том молибден-зэсийн ордуудын нэг

Баянхөндий төслөөс зүүн зүгт 35 км-т Зуун Мод порфирийн цогцолбор оршдог ба Ази тив дэх хөгжүүлэлт хийгдээгүй хамгийн том молибден-зэсийн нөөц бүхий энэхүү цогцолбор нь 270 сая фунт молибден, 330 сая фунт зэсийн баттай, бодитой нөөц болон таамаг нөөц² агуулж байна.

2023 онд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр хүдэржилтийг гүндээ болон ордын хязгаарын дагуу тэлж, одоогийн нөөцийн бүсээс хойш 1.7 км-т хүдэржилт илрүүлсэн. Бид эрдсийн нөөцийг шинэчлэхээр зөвлөх үйлчилгээ авч ажиллаж байгаа ба энэ оны эцэст боловсруулах урьдчилсан эдийн засгийн үнэлгээ ("PEA")-нд зориулсан техникийн болон зах зээлийн судалгаанууд хийгдэж байна.

Молибденийг өндөр чанарын гангийн хайлшид өргөнөөр ашигладаг тул эрчим хүчний дэд бүтэц, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл болон батлан хамгаалах салбарт ашиглах зорилгоор БНХАУ, Солонгос, Япон болон Канад зэрэг улсууд критикал ашигт малтмал гэж тодорхойлсон. Мөн хагас дамжуулагчийн салбарт эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Зах зээлийн судалгаагаар ирэх онуудад жилд дунджаар 50 гаруй фунт молибденийн нийлүүлэлтийн хомсдол үүсэх төлөвтэй байгаа тул молибденийн ханш тогтвортой, цаашид Зуун Мод төслийг хөгжүүлэхэд эдийн засгийн таатай нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Түүнээс гадна, Зуун Мод төслөөс хойд зүгт 2.2 км-т тусгай зөвшөөрлийн талбайд томоохон зэс-мөнгөний хэтийн төлөв бүхий талбай оршдог. Өмнө нь гүйцэтгэж байсан өрөмдлөгийн хөтөлбөрөөр 1.3% зэс, 9.24 г/т мөнгөний агуулга бүхий 34 метрийн интервал огтолсон. Энэхүү томоохон порфирийн цогцолборт ирээдүйд хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлснээр одоогийн мэдэгдэж буй молибденийн системээс гадна илүү олон нээлтүүдийг хийх боломжтой.

Ирээдүйн нээлтүүдийн суурь

Одоогийн илрүүлсэн төслүүдээс гадна Эрдэнэ Ресурс нь өнгөрсөн 20 гаруй жилийн турш Транс Алтайн Террейнд төвлөрч ажилласан тул томоохон геологийн мэдээллийн санг бүрдүүлсэн. Дэлхийн томоохон ордуудыг агуулдаг Төв Азийн Орогенийн Бүсийн энэхүү хэсэгт хайгуул маш бага хийгдсэн. Монгол орны геологийн

² "Zuun Mod Porphyry Molybdenum-Copper Project, Southwest Mongolia, National Instrument 43-101 Technical Report" нэртэй 2011 оны 6 сард боловсруулсан техникийн тайлантай SEDAR+ дэх хуудсаас танилцана уу.

онцлогийн талаар мэдлэг, туршлага арвин Эрдэнэ Ресурсийн хайгуулын баг нь тендерт оролцох замаар ирээдүйд нөөцийг нэмэгдүүлэх боломжуудыг судалж байна. Австрали Улсын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь нийт газар нутгийн гуравны нэгийг эзэлдэг, Монгол Улсын хувьд энэхүү хэмжээ нь 4% байгаа нь Монголын хайгуулын салбар цаашид хөгжих асар том орон зай байгааг харуулж байна. Бид тендерээс гадна хэтийн төлөв бүхий бүс нутагт хувийн компанид хөрөнгө оруулалт хийн, нөөцийг нэмэгдүүлэх боломжуудыг судална.

Баянхөндий төслийг суурь төсөл болгон Алтан Нар, Зуун Модыг хөгжүүлэх болон ирээдүйн нээлт хийх боломжтой хэтийн төлөв бүхий талбайнуудад хайгуул судалгаа хийснээр Эрдэнэ Ресурсийн үнэ цэн дараагийн шатанд хүрэх боломжтой. Баянхөндий төсөл олборлолтын шат руу ойртож буй энэ үед бид Хөндий Эрдсийн Дүүргийг үргэлжлүүлэн нээж, хөгжүүлж, тэлснээр Эрдэнэ Ресурсийг хайгуул, нөөцийн өсөлт, олборлолтын олон төсөл бүхий олон талт уул уурхайн компани болгох зорилгынхоо төлөө итгэл төгс урагшилж байна.

Амжилтыг үргэлжлүүлэх стратегийн түншлэл

Манай компани өнгөрсөн 20 жилийн турш Монгол Улсад үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд манай удирдлагын баг тус улсад 30 гаруй жил ажилласан арвин туршлагатай. Энэ хугацаанд Монгол Улс нь чөлөөт зах зээлийн тогтолцоонд суурилсан ардчилсан нийгэм болон төлөвшиж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих таатай орчныг бүрдүүлсэн. Өнөөдөр Монгол Улс нь дэлхийн жишигт нийцсэн хэд хэдэн томоохон уурхайг байгуулсан бөгөөд үүний нэг нь 2030 он гэхэд дэлхийн дөрөв дэх том зэсийн олборлогч болох Оюу Толгой зэс-алтны уурхай юм.

Бид энэ хугацаанд хайгуул, хөгжүүлэлт, ашиглалт болон үйл ажиллагааны удирдлагын чиглэлээр гүнзгий мэдлэг, туршлага хуримтлуулан ажилласан. Манай хайгуулын баг нь Монголын алт, зэсийн системийн тухай мэдлэг туршлага өндөртэй хамт олон бөгөөд үүндээ тулгуурлан Баянхөндий, Алтан Нар, Улаан болон Зуун Мод молибден-зэсийн порфирийн цогцолборыг нээн илрүүлсэн.

Хайгуулаас олборлолт руу шилжихдээ бид Монголын хамгийн том хувийн уул уурхайн компани болох Монголиан Майнинг Корпорэйшн (“ММС”)-тэй стратегийн түншлэл байгуулсан. ММС нь Баянхөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн охин компани болох Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)-д 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийн, 50%-ийг эзэмших болсон. Түүнээс гадна, Баянхөндий алтны төслийн бүтээн байгуулалтын хүрээнд 80 сая ам.доллар хүртэлх хувьцаа эзэмшигчийн зээл олгосноор Баянхөндий алтны төслийн бүтээн байгуулалтын санхүүжилтийг бүрдүүлсэн.

ММС нь олон салбарт үйл ажиллагаа явуулдаг Монголын тэргүүлэгч групп компани болох Эм Си Эс группийн охин компани юм. Эм Си Эс групп нь инженерчлэл,

барилга, эрчим хүч, харилцаа холбоо, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдаа, эрүүл мэнд болон үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг. Баянхөндий төслийн барилга, инженерчлэл болон худалдан авалтын цогц гэрээг ("EPC") тус группийн охин компани Эм Си Эс Проперти гүйцэтгэсэн ба цахилгаан дамжуулах 110 кВ-ын агаарын шугамын бүтээн байгуулалтыг Өмнөговь аймгийн Нарийн сухайт дэд станцаас Баянхөндий төсөл рүү хийж, Баянхөндий төслийг цахилгаанаар хангах эрчим хүч худалдан авах гэрээг Эм Си Эс Интернэйшн ХХК-тай байгуулсан. Энэ шугам нь зөвхөн Баянхөндий төсөл төдийгүй Хөндий Эрдсийн Дүүргийн өргөтгөл төслүүдийг эрчим хүчээр хангах юм.

Мөн, Монгол Улсад 2.5 гаруй тэрбум еврогийн хөрөнгө оруулалтыг хийсэн Монголын хамгийн том гадаадын хөрөнгө оруулагч болох Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк ("ЕСБХБ") нь Эрдэнэ Ресурсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ирсэн хөрөнгө оруулагч юм. 2019 онд ЕСБХБ нь Эрдэнэ Ресурс-д хөрөнгө оруулалт хийснээр бид бүтээн байгуулалтын үе шат руу шилжих техникийн судалгаануудыг гүйцэтгэх боломжтой болсон. ЕСБХБ нь манай компанийн Монгол дахь үйл ажиллагааг тууштай, идэвхтэй дэмжсээр ирсэн.

Эрдэнэ Ресурсийн амжилтын бас нэг чухал хүчин зүйл нь манай тогтвортой, биднийг үргэлж дэмждэг хөрөнгө оруулагчид юм. Үүнд уул уурхай, эрдсийн салбарт хөрөнгө оруулдаг Эрик Спротт, томоохон хөрөнгө оруулалтын сангууд болон зүүн Канадын хувьцаа эзэмшигчид багтдаг. Бид 2025 оны 12 дугаар сард Торонтогийн хөрөнгийн биржид бүртгүүлсний 20 жилийн ойгоо тэмдэглэх гэж байна. Үүний зэрэгцээ бид Торонтогийн хөрөнгийн бирж, Монголын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй анхны ба цорын ганц компани гэдгээрээ бахархалтай байдаг бөгөөд 7,000 гаруй монгол хувьцаа эзэмшигчдийнхээ дэмжлэгийг өндөр үнэлдэг.

Нийгмийн хариуцлага ба тогтвортой байдал

Эрдэнэ Монгол ХХК нь Баянхөндий төслийн хүрээнд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн удирдлагыг онцгой анхаарч, ач холбогдол өгсөөр ирсэн. Усны хэрэглээг хязгаарлах зорилгоор усны дахин ашиглалт, боловсруулалт болон хуурай хаягдлын технологийг нэвтрүүлж, төслийн талбайд хүлэмж байгуулан орон нутгийн уугуул мод ургамлыг тарьж ургуулан, нутгийн унаган экосистемийг дэмжихээс гадна Эхийн голын баянбүрдэд тогтвортой газар тариалангийн үйл ажиллагааг дэмжин хөрөнгө оруулсаар ирсэн.

Түүнээс гадна, Эрдэнэ Монгол ХХК нь Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран, нутагшлын бүс нь Эрдэнийн тусгай зөвшөөрлийн талбайгаас 100 гаруй км-т, тусгай хамгаалалттай бүс нутагт амьдардаг ховордож буй говийн баавгай Мазаалайг хамгаалахад хамтарч ажиллаж байна.

2025 оны 6 сарын байдлаар Баянхөндий төслийн талбайд 700 гаруй ажилтан ажиллаж байгаа ба тэдний 99% нь Монгол ажилтнууд байна. Эдгээр ажилтнуудын

30% нь Баянхонгор аймгаас, тэр дундаа Баянхөндий төслийн хамгийн ойрын суурин газар болох Шинэжинст сумын иргэдээс бүрдэж байна. Мөн нийт ажилтнуудын 28% нь эмэгтэйчүүд ажиллаж байгааг онцлох нь зүйтэй. Баянхөндий төсөл нь Монгол Улсад дотоодын боловсон хүчин, үндэсний компанийн оролцоотойгоор баригдсан анхны томоохон уул уурхайн төсөл болох ба энэ нь орон нутгийн чадавхыг бэхжүүлэх, улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах эрхэм зорилтыг маань илтгэж байна.



Зураг: Эрдэнэ Монгол ХХК-ийн хүнд даацын тээврийн хэрэгслийн операторын дадлагажигч

Баянхөндий төслийн баг нь төслийг амжилттай хэрэгжүүлэх чухал үүрэгтэйгээс гадна Монгол Улсад тогтвортой, хүртээмжтэй уул уурхайн салбарыг бүтээхэд чухал хувь нэмрээ оруулж байна.

Дүгнэлт


Сүүлийн нэг жилийн хугацаанд Эрдэнэ Ресурс нь хайгуулын компаниас олборлогч компанийн чиглэлд шилжих түүхэн шилжилтийнхээ хүрээнд томоохон алхмуудыг хийж гүйцэтгэлээ. 2025 оны 3-р улиралд алтны олборлолт эхэлснээр компанийн үнэлгээний эргэлтийн цэг болно гэж харж байна. Алтны үнийн өсөлт, үйл ажиллагааны мөнгөн урсгал нь Хөндий Эрдсийн Дүүргийн асар их хайгуулын боломжийг бодитоор хэрэгжүүлэх нөхцөлийг бидэнд олгоно.

Үнэт болон суурь металлын эрэлт өсөж, үүний дүнд дэлхий дахинд металлын үнэ нэмэгдэж буй өнөөгийн нөхцөл нь Хөндий Эрдсийн Дүүрэгт олон төрлийн, өндөр үр ашигтай ашигт малтмалын баялаг бүс нутгийг хөгжүүлж, урт хугацааны амжилтыг үргэлжлүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

Эцэст нь, энэхүү замналын туршид бидэнтэй хамт байж, чин сэтгэл, тууштай хөдөлмөрөө зориулсан баг хамт олон болон бидний үйл ажиллагааг дэмжиж ирсэн

хувьцаа эзэмшигчид, оролцогч талууддаа чин сэтгэлийн талархлыг өргөн дэвшүүлье. Та бүхний тууштай дэмжлэг нь биднийг энэ шийдвэрлэх мөчид хүрэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан билээ.

Бид ирээдүйд итгэл дүүрэн байна. Хийж бүтээсэн хөдөлмөрийн үр шим, өгөөжийг ирэх жилүүдэд бүх оролцогч талуудтайгаа хуваалцахыг тэсэн ядан хүлээж байна.



Петер К.Акерли
Ерөнхийлөгч ба Гүйцэтгэх захирал
2025 оны 6 дугаар сар

Мэргэшсэн этгээд (геологич)

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба энэхүү Хувьцаа эзэмшигчдэд хүргэх захидалд дурдсан техникийн мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Дээр дурдсан эрсдэлийн хүчин зүйлс нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй бүх эрсдэлийг жагсаагаагүй болно. Нэмэлт эрсдэлүүдийг компанийн хамгийн сүүлийн Жилийн Мэдээллийн Тайлангийн “Эрсдэлийн Хүчин Зүйлс” хэсэгт дурдсан бөгөөд энэхүү тайланг SEDAR+ дахь компанийн хуудсаар дамжуулан www.sedarplus.ca хаягаас үзэх боломжтой.

Хувьцаа эзэмшигчдэд хүргэх захидалд багтсан санхүүгийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээлэл нь холбогдох үнэт цаасны хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлогдсон бөгөөд уг мэдээллийг энэхүү захидлын огнооны байдлаар компанийн удирдлага баталсан. Ийм төрлийн мэдээллийг урьдчилсан таамаглал болон ирээдүйн төлөвлөгөөг танилцуулах зорилгоор танилцуулсан бөгөөд энэхүү мэдээллийг зориулагдсан зорилгоос өөрөөр ашиглахгүй байхыг уншигчдад анхааруулж байна.